



ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 5/07

Зуунмод

Энхбаатарын Номин-Эрдэнийг
ажлаас чөлөөлөх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.9, Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 9 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Э.Номин-Эрдэнэ нь өөр байгууллага, албан тушаалд шилжин томилогдож байгаа тул 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хуулийн мэргэжилтнээс чөлөөлсүгэй.

2.Э.Номин-Эрдэнэд 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл архив, бичиг хэрэг, няравын ажлыг хавсран гүйцэтгэсэн ажлын нэмэгдлийг тооцож олгохыг Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНХУЯГ





**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 408

Зуунмод сум

**Болдын Болдбаярыг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол улсын "Төрийн албаны тухай хууль"-ийн 23 дугаар зүйл 23.2.1, 26 дугаар зүйл 26.1, 26.2, 26.3, 27 дугаар зүйл 27.1.2 дахь заалт, 57 дугаар зүйл 57.2.2, "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 41 дүгээр зүйл 41.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2022 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" 491 дүгээр Тогтоол, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр Тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10 дахь хэсэг, Засгийн Газрын 2019 оны "Журам батлах тухай" 9 дүгээр Тогтоол, 2023 оны 312 дугаар Тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 сарын 05-ны өдрийн 526 дугаар Тогтоолын 1,3 дахь заалт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/758 Захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Хуулийн мэргэжилтэний албан үүргийг Болдын Болдбаяраар 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн гүйцэтгүүлсүгэй.
2. Б.Болдбаярын албан тушаалын сарын үндсэн цалинг ТЗ-9 зэрэглэл 1,100,000 (Нэг сая нэг зуун мянга) төгрөгөөр тогтоож, Зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 17 хувиар, орон нутагт ажилласан нэмэгдлийг улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн төсвөөс 50 хувиар бодож тус тус олгосугай.
3. Б.Болдбаярын албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэлүүдийг 2024 оны 02 сарын 01-өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажил хүлээлцүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ахлах мэргэжилтэн /А.Зоригоо/-д үүррэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНХУЯГ





**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 5/09

Зуунмод сум

Төмөрхуягийн Ууганбаярыг
түр томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, 2022 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" 491 дүгээр тогтоол, 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 312 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 526 дугаар тогтоолын 1, 3, Төв аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр 20-ны өдрийн А/758 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Архив, бичиг хэргийн ажилтан, няраваар Төмөрхуягийн Ууганбаярыг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн түр томилсугай.

2. Т.Ууганбаярын албан тушаалын сарын үндсэн цалинг ТҮ-5 зэрэглэл 912,000 (Есөн зуун арван хоёр мянга) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлийг 3 хувиар тогтоосугай.

3. Т.Ууганбаярын албан тушаалын үндсэн цалин, алба хаасаны нэмэгдлийг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг Нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНХУЯГ

ШТА1295 14701004



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 5/10

Зуунмод сум

┌ Амгалангийн Зоригоог ажилд
томилох тухай ┐

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.3, 27 дугаар зүйлийн 27.1.2, 44 дүгээр зүйлийн 44.1, 57 дугаар зүйл 57.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.3 дахь заалтууд, Засгийн газрын 2018 оны 382 дугаар Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор баталсан "Журамд өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 2, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр Тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10 дахь хэсэг, 2023 оны 312 дугаар тогтоолоор баталсан "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 1, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 526 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" тогтоолын 1.3 дахь заалт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/758 дугаар захирамжаар баталсан "Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм, бүтэц орон тогтоог батлах тухай" захирамжийн 2 дугаар хавсралт, Орон нутгийн өмчийн газрын 2024 оны Б/01 дүгээр тушаал, Авилгатай тэмцэх газрын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 05/2833 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Ахлах мэргэжилтний албан тушаалд Амгалангийн Зоригоог 2024 оны 01 дугаар сарын 02-ний өдөр буюу тухайн албан тушаалд шилжүүлсэн өдрөөр томилсугай.
2. А.Зоригоогийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТЗ-8 зэрэглэл 1,200,000 (Нэг сая хоёр зуун мянга) төгрөгөөр тогтоож, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 18 хувиар, орон нутагт ажилласан нэмэгдлийг улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн төсвөөс 50 хувиар бодож тус тус олгосугай.
3. А.Зоригоогийн албан тушаалын үндсэн цалин, нэмэгдлүүдийг 2024 оны 01 сарын 02-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.
4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажил хүлээлцүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хуулийн мэргэжилтэнд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНХУЯГ